

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
НБУГ	Нисэх буудлуудын удирдах газар

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	3
2.Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3.Менежментийн захидал.....	11
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/842
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

БУЯНТ УХАА ДАХЬ ЧИНГИС ХААН
ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН
ЗАХИРАЛ Д.МӨНХБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Буянт-Ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буянт-ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2020\03\13\SAG84.Docx

001051472

Аудитын гол асуудал


- Он удаан жил болсон авиа компаниудаас авах 9,026.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- 207.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер зарлаагүй, харьцуулалтын аргаар худалдан авсан;
- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, 31.3 сая төгрөгийн хөрөнгийг Нисэх буудлын удирдах газарт хүлээлгэж өгсөн, данс бүртгэлээс хасаагүй зэрэг нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Буянт-ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын захирал Д.Мөнхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 05-наас 2020 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Л.Мөнхцацрал хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 09/а/119 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго “Нисэх буудлын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж, үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг бүрдүүлсэн үндэсний шилдэг байгууллага болоход оршино” гэж тодорхойлсон байна.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, тогтвортой хөгжил, үйлчилгээний төгөлдөршил, чадварлаг ажилтан гэсэн үнэт зүйлийг баримталж, Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилласан байна. Үйл ажиллагааны чиглэлийг байгууллагын дүрэмд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон улс, орон нутгийн агаарын шугамд нисэж буй агаарын хөлгөөр зорчигч болон угтан авагч, үдэн гаргагчдад олон улсын стандартын түвшинд хүрсэн үйлчилгээ үзүүлнэ;
- Иргэний нисэхийн аюулгүй байдалд гарч болзошгүй халдлагаас хамгаалах зорилгоор зорчигч, ачаа тээшинд аюулгүй байдлын үзлэг болон харуул хамгаалалтын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулна;
- Нисэх буудлын үйлчилгээг дүрэм, журам, зааврын дагуу гүйцэтгэж техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах;
- Нисэх буудал, аэродромын орчмын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах;
- Нисэх буудлын үйлчилгээний менежмент, технологийг боловсронгуй болгож, талбайн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг оновчтой, үр ашигтай ажиллуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашин эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Интер-актив ХХК-ийн Veritech ер программ хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 10 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын орлогын тайлангийн нийт мөнгөн орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Орлогын хэмжээнээс шалтгаалж, зардал зарцуулагдах тул суурь үзүүлэлтээр нийт мөнгөн орлогыг сонгосон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд суурь үзүүлэлтийн дүн 30,504.3 сая төгрөгөөс тооцон 305.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 354.6 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,077.0 сая төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансдад материаллаг өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,072.9	14,002.3	10,929.4
Авлага	17,431.6	14,912.0	(2,519.7)
Урьдчилгаа	58.9	8.7	(50.2)
Бараа материал	576.1	743.9	167.8
Үндсэн хөрөнгө	59,286.6	55,836.2	(3,450.4)
Нийт хөрөнгө	80,426.0	85,503.0	5,077.0
Өр төлбөр	448.0	167.3	(280.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	79,978.1	85,335.8	5,357.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	80,426.0	85,503.0	5,077.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,929.4 сая төгрөгөөр өссөн нь урд оны авлагын үлдэгдлээс 2,519.7 сая төгрөг барагдуулсан, тайлант оны мөнгөн хөрөнгийн орлого, зарлагаас давсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 2,519.7 сая төгрөгөөр буурсан нь бусад богино хугацаатай авлага 4,495.3 сая төгрөгөөр буурсан, дансны авлага 80.5 сая төгрөгөөр, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 1,895.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэлд 12,782.4 сая төгрөгийн дансны авлага, 1,897.1 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, 232.5 сая төгрөгийн бусад богино хугацаат авлага байгаагийн 10,810.7 сая төгрөг нь дотоодын авиа компаниудаас авах авлага байна.

Урьдчилгаа данс 50.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд урьдчилж шилжүүлсэн аудит баталгаажуулалтын ажлын хөлс, бараа материал бэлтгэн нийлүүлэхэд урьдчилж төлсөн зардлыг тайлант онд зардалд хүлээн зөвшөөрч, бараа материалыг хүлээн авснаар үлдэгдэл 8.7 сая төгрөг болж буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 167.8 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал 197.8 сая төгрөг, түүхий эд материал 37.3 сая төгрөг, дуусаагүй үйлдвэрлэл 2.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 2.5 сая төгрөг, бусад бараа материалын үлдэгдэл 47.0 сая төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй болсон 15.7 сая төгрөгийн бараа материал байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 3,450.4 сая төгрөгөөр буурсан нь 130.1 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, 2.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсан, тайлант онд 3,831.8 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулж, 188.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 280.7 сая төгрөгөөр буурсан нь татварын өр 331.1 сая төгрөгөөр буурч, дансны өглөг 40.0 сая төгрөг, бусад богино хугацаат өр 10.3 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Өр төлбөр дансны 59.5 сая төгрөг нь гадаадын авиа компанид төлөх өглөг, 2.3 сая төгрөг татварын, 105.5 нь бусад байгууллагад төлөх өглөг байна.

Эздийн өмчийн дүн тайлант үеийн цэвэр ашиг 5,399.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 85,335.8 сая төгрөг болсон байна.

2.9. Зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны тодотгосон зорилтот түвшний төлөвлөгөөнд бууралт хөөрөлтийн орлого 12,577.3 сая төгрөг, буудлын хураамж 12,283.1 сая төгрөг, үйл ажиллагааны бусад орлого 8,740.0 сая төгрөг нийт 33,600.6 сая төгрөгийн орлого төлөвлөснөөс гүйцэтгэлээр бууралт хөөрөлтийн орлого 15,777.2 сая төгрөг, буудлын хураамж 14,014.3 сая төгрөг, үйл ажиллагааны бусад орлого 10,055.3 сая төгрөг нийт 39,846.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 6,246.2 сая төгрөг буюу 19 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант онд дотоодын болон гадаад авиакомпаниудын гүйцэтгэсэн нислэгийн тоо төлөвлөсөн хэмжээнээс давсан нь орлогыг өсгөх шалтгаан болжээ.

Урсгал зардалд 29,417.5 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 28,788.7 сая төгрөг зарцуулж 628.8 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Урсгал зардал 628.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь үндсэн цалинг 2 дугаар улирлаас нэмж тооцон олгосноос цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 557.8 сая төгрөг, худалдан авах ажиллагааг тайланд онд багтааж гүйцэтгээгүйгээс нормативт зардал 271.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 71.4 сая төгрөгөөр тус тус дутуу хэрэгжсэнтэй холбоотой байна.

Тайлант онд цахилгаан дулааны тарифт өртөг нэмэгдсэнтэй холбоотой байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35.4 сая төгрөг, шатахууны үнэ 4-5 хувиар өссөн, нислэгийн тоо ихэссэнээс шувуу, мал амьтан агаарын хөлөгтэй мөргөлдөхөөс сэргийлэх үргээлгийн тоо ихэссэнтэй холбоотой бараа материалын зардал 119.1 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна. Мөн газрын дахин үнэлгээ хийгдэж, бүсчлэл өөрчлөгдөн, газрын төлбөр нэмэгдсэнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 43.8 сая төгрөг, үйлдвэрлэл борлуулалт нэмэгдсэнтэй холбоотой түүхий эд материалын зардал өсч, бараа үйлчилгээний бусад зардал 85.6 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газарт төвлөрүүлэх шилжүүлгээр 10,000.0 сая төгрөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт түрээсийн орлогын 30 хувь болох 500.2 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 10 эрсдэлд горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,434.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 207.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,226.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан, тус бүр 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 2 нэр төрлийн 207.8 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг нээлттэй тендер зарлаагүй, харьцуулалтын аргаар худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасанд тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

Аудитаар илэрсэн 9,434.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Аудитаар гүйцэтгэсэн бараа материалын хэсэгчилсэн тооллогоор 7.8 сая төгрөгийн хөрөнгө дутагдаж, тооллогоос хойш хөрөнгийг нөхөн бүрдүүлж, алдаа зөрчлийг арилгасан нь анхаарал татахуйц асуудал байна.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан 5,533.0 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайлан, компанийн дүрэмд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаал баталсан "Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлж журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ", 4.1.3-т "Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувь эзэмшигчийн хувь" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа асуудалд дараагийн аудитаар горим, сорил хэрэгжүүлж, гүйцээн шалгах;

3. Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал нь "Хөшигийн хөндий" олон улсын нисэх буудлыг ашиглалтад орсноор нислэгтэй холбоотой үйлчилгээг шилжүүлж, үндсэн чиг үүрэгт өөрчлөлт орох төлөвтэй байна. Үүнтэй холбоотойгоор өөрчлөн байгуулалтаар шилжих авлага, өглөг, хөрөнгийн хөдөлгөөнийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 37 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 229.3 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 9,434.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 354.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Дансны авлагын 12,782.4 сая төгрөгийн үлдэгдлийн 84.3 хувь буюу 10,810.7 сая төгрөг нь дотоодын авиа компаниудаас авах авлагыг барагдуулаагүй байна. Үүнээс 2014 оноос өмнө үүссэн 8,576.2 сая төгрөг, 2015 онд үүссэн 407.3 сая төгрөг, 2016 онд үүссэн 42.7 сая төгрөг буюу нийт 9,026.2 сая төгрөгийн авлага нь МИАТ компани, АэроМонголиа ХХК, Хүннү Эйр ХХК-аас тус тус авах авлага байна. /Авлагыг насжилтаар нь хавсралт 1-д үзүүлэв/ Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Авлага найдваргүй болж алдагдал хүлээх, хөрөнгийн эргэц, үр ашиг буурах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Олон жилийн насжилттай, өндөр дүнтэй дээрх авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах /Чингис хаан олон улсын нисэх буудал болон ИНЕГ-ын холбогдох албан тушаалтнууд хариуцан шийдвэрлэх/

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.2 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Орон нутгийн нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой 93.5 сая төгрөгийн авлага, 240.1 сая төгрөгийн өглөгийг ИНЕГ-ын авлага, өглөгийн систем хоорондын тооцоогоор хааж, бэлэн бус тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар тохирч, системийн авлагыг 140.6 сая төгрөгийн цэвэр дүнгээр нэгтгэж толилуулсан нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 2-т "Дансны авлага: Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө

худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Тайлан буруу илэрхийлэгдэх, авлагын тооцоотой холбоотой маргаан үүсэх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Системийн байгууллагуудын авлагыг удирдах дээд байгууллагын тооцоонд оруулж тооцолгүй, холбоотой талаас авах цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр илэрхийлж байдлын тайланд тусгах;

Систем хоорондын авлага өглөгт зөвхөн ИНЕГ-ын багц дүрэмд тусгасан эрх үүргийн гүйцэтгэлтэй холбоотой үүссэн ажил гүйлгээг бүртгэх

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Их хэмжээгээр худалдан авч нөөцөлснөөс 15.7 сая төгрөгийн маягт хүчингүй болж үргүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Үргүй зардал гарах

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үргүй зардал гаргахгүй байх

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, Нисэх буудлын удирдах газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар 31.3 сая төгрөгийн хөрөнгийг Нисэх буудлын удирдах газарт хүлээлгэж өгсөн боловч данс бүртгэлээс хасаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4/-т "төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл:

Санхүү, бүртгэл, тайлагналын зарчим алдагдах, хөрөнгө үрэгдэх

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд ирүүлсэн тайлбарын үндэслэлийг хянаж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

3.5 Жижиг мөнгөн сангийн бүртгэлтэй холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

а/ Жижиг мөнгөн кассын үйл ажиллагааны журмаар зөвшөөрөгдөөгүй, заагдсан үнийн дүнгээс давсан 9.9 сая төгрөгийн зардлыг бэлнээр зарцуулсан нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын 2.2-т “Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картын дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар /ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно”, 6.3-д “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

б/ Кассаар хүлээн авсан орлогыг ажлын дараагийн өдөрт тухай бүр харилцах дансанд тушаагүйгээс кассын зарим саруудын үлдэгдэл их дүнтэй гарсан байна. Тухайлбал: 2019 оны эхний үлдэгдэл 16.5 сая, 3 дугаар сар 34.2 сая, 9 дүгээр сар 10.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа зэрэг нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэж заасанд нийцэхгүй байна.

3.5.2. Эрсдэл:

Мөнгөн хөрөнгө шамшигдах, алга болох

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн кассаар хүлээн авсан орлогыг тухай бүр харилцах дансанд тушааж, Төсвийн байгууллагын мөнгөн кассын журмын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3.6 Зардлын данстай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт

Удирдлага буруутай шийдвэр гаргаснаас үндэслэлгүй халагдсан ажилтанд 2.7 сая төгрөгийн нөхөн олговор олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасанд нийцэхгүй байна.

3.6.2. Эрсдэл:

Үргүй зардал гарах

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй халагдсан ажилтанд нөхөн олговор олгохдоо гэм буруутай албан тушаалтнаар төлүүлж байх

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлд ирүүлсэн тайлбарыг үндэслэн акт тогтоох асуудлыг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	3,072,881.6	14,002,283.0
1.1.2	Дансны авлага	12,701,862.1	12,782,385.8
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,980.1	1,897,064.0
1.1.4	Бусад авлага	100,524.6	91,914.4
1.1.6	Бараа материал	576,070.7	743,908.6
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	58,886.6	8,680.0
1.1.10	Системийн авлага	4,627,240.0	140,591.1
	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,139,445.8	29,666,826.9
1.2.1	Үндсэн хөрөнгө	58,991,030.4	55,291,546.7
1.2.2	Биет бус хөрөнгө	56,882.8	20,452.2
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	238,686.7	524,207.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	59,286,600.0	55,836,206.2
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	80,426,045.8	85,503,033.1
2.1.1.1	Дансны өглөг	8,631.8	48,662.6
2.1.1.3	Татварын өр	333,649.9	2,584.6
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	30,360.2	42,241.3
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	75,337.0	73,779.5
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	447,978.9	167,267.9
2.2	Өр төлбөрийн нийт дүн	447,978.9	167,267.9
2.3	Эздийн өмч	18,136,422.1	18,136,422.1
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18,136,422.1	18,136,422.1
2.3.8	Хойшлогдсон орлого	151,297.9	132,871.9
2.3.9	Хуримтлагдсан ашиг	61,690,346.8	67,066,471.1
	Эздийн өмчийн дүн	79,978,066.9	85,335,765.2
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	80,426,045.8	85,503,033.1

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	29,394,830.4	35,456,951.1
2	Борлуулалтын өртөг	22,446,610.5	20,017,696.9
3	Нийт ашиг (алдагдал)	6,948,219.9	15,439,254.2
4	Түрээсийн орлого	1,930,214.2	1,874,168.1
5	Хүүний орлого	247,921.6	519,085.8
8	Бусад орлого	1,454,340.9	1,597,561.3
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,508,125.4	11,557,173.3
12	Бусад зардал	4,424,919.1	1,606,374.2
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	384,038.5	319,651.5
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,031,690.5	6,586,173.4
19	Орлогын татварын зардал	1,528,938.9	1,186,550.7
20	Татварын дараах ашиг (алдагдал)	3,502,751.6	5,399,622.7
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,502,751.6	5,399,622.7

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	36,795,965.9	44,142,165.7
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	33,611,917.4	39,931,743.5
		3,184,048.4	4,210,422.2
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
1.2.1	Ажиллагчдад төлсөн	39,574,940.3	33,642,335.3
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,974,633.8	10,310,573.7
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,567,751.2	2,861,360.5
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	12,657,303.7	2,269,804.2
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	915,211.2	1,048,775.1
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	29,848.1	-
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	4,384,346.3	4,988,054.0
		5,045,846.0	12,163,767.7
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
		(2,778,974.5)	10,499,830.4
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	265,379.1	519,085.8
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	389,411.2	89,514.8
		389,411.2	89,514.8
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
		(124,032.1)	429,571.0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
		(2,903,006.6)	10,929,401.4
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
		(2,903,006.6)	10,929,401.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
		5,975,888.2	3,072,881.6
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
		3,072,881.6	14,002,283.0

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1.0	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	58,194,334.9	58,194,334.9
2.0	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(6,739.7)	(6,739.7)
3.0	Залруулсан үлдэгдэл	-	-	-	58,187,595.2	58,187,595.2
4.0	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,502,751.6	3,502,751.6
5.0	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6.0	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	151,297.9	-	151,297.9
7.0	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8.0	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	18,136,422.1	-	-	-	18,136,422.1
9.0	2018 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	18,136,422.1	-	151,297.9	61,690,346.8	79,978,066.9
10.0	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11.0	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
12.0	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,399,622.7	5,399.6
13.0	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14.0	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(18,426.0)	(23,498.4)	(41,924.4)
15.0	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16.0	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17.0	2019 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	18,136,422.1	-	132,871.9	67,066,471.1	85,335,765.2

4.5 Аудит хийсэн зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	29,417,501.5	28,788,651.8	628,849.7	97.9
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,636,430.0	17,026,200.5	610,229.5	96.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	11,992,579.0	11,492,305.5	500,273.5	95.8
Үндсэн ба нэмэгдэл цалин	10,184,060.0	9,885,424.3	298,635.7	97.1
Хоолны үнийн хөнгөлөлт	1,026,080.0	1,020,907.9	5,172.1	99.5
Гэрээт ажлын цалин	782,439.0	585,973.2	196,465.8	74.9
Ажил олгогчоос төлөх НДШ	1,618,998.2	1,561,488.2	57,510.0	96.4
Тэтгэврийн даатгал	1,019,369.2	986,793.5	32,575.7	96.8
Тэтгэмжийн даатгал	119,925.8	116,119.1	3,806.7	96.8
ҮОМШӨ-ний даатгал	215,866.4	207,002.4	8,864.0	95.9
Ажилгүйдлийн даатгал	23,985.2	22,870.3	1,114.9	95.4
Эрүүл мэндийн даатгал	239,851.6	228,702.9	11,148.7	95.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	832,438.9	867,864.9	(35,426.0)	104.3
Гэрэл, цахилгаан	565,844.0	582,078.2	(16,234.2)	102.9
Дулаан, халаалт	178,512.3	201,692.1	(23,179.8)	113.0
Цэвэр, бохир ус	88,082.6	84,094.6	3,988.0	95.5
Хангамж, бараа материалын зардал	742,317.6	867,489.1	(125,171.5)	116.9
Бичиг хэрэг	51,732.3	52,019.6	(287.3)	100.6
Шатахуун /тээвэр/	378,157.5	497,256.2	(119,098.7)	131.5
Шуудан, холбоо	66,732.1	66,079.4	652.7	99.0
Хог, хаягдал устгах зардал	222,820.7	229,236.2	(6,415.5)	102.9
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	22,875.0	22,897.7	(22.7)	100.1
Нормативт зардал	439,720.9	168,443.2	271,277.7	38.3
Нормын болон дүрэмт хувцас	439,720.9	168,443.2	271,277.7	38.3
Эд, хогшил урсгал засварын зардал	710,548.6	639,136.7	71,411.9	89.9
Багаж, техник хэрэгсэл	675,656.6	580,133.0	95,523.6	85.9
Барилга	65,700.0	65,666.8	33.2	99.9
Тоног төхөөрөмж	250,000.0	250,431.0	(431.0)	100.2
Автомашин	75,000.0	86,332.0	(11,332.0)	115.1
Аэродром	273,500.0	167,083.1	106,416.9	61.1
Гал унтраах зардал	11,456.6	10,620.1	836.5	92.7
Хөдөлмөр хамгааллын зардал	34,892.0	59,003.7	(24,111.7)	169.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	505,158.0	548,949.4	(43,791.4)	108.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	39,841.0	18,139.4	21,701.6	45.5
Мэдээлэл технологийн үйлчилгээ	11,000.0	10,753.4	246.6	97.8
Газрын төлбөр	428,404.6	485,794.8	(57,390.2)	113.4
Банкны үйлчилгээний хураамж	13,000.0	18,577.3	(5,577.3)	142.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх зардал	12,912.4	15,684.5	(2,772.1)	121.5
Бараа үйлчилгээний бусад зардал	794,668.8	880,523.5	(85,854.7)	110.8

Бараа үйлчилгээний бусад зардал	120,000.0	82,523.7	37,476.3	68.8
Түүхий эд	674,668.8	797,999.8	(123,331.0)	118.3
Мэдээлэл, сурталчилгааны зардал	36,721.0	36,086.2	634.8	98.3
Харуул хамгаалалтын зардал	7,662.0	4,121.5	3,540.5	53.8
Холбооны суваг ашигласны төлбөр	232,372.8	257,735.2	(25,362.4)	110.9
Үл хөдлөх хөрөнгийн татвар	525,295.5	526,631.7	(1,336.2)	100.3
Биеийн тамир уралдаан, тэмцээн	4,000.0	6,695.5	(2,695.5)	167.4
Олон улсын гишүүний татвар	9,988.8	10,119.0	(130.2)	101.3
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	965,031.4	921,062.2	43,969.2	95.4
Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж	245,820.1	318,665.7	(72,845.6)	129.6
Тэтгэвэр тэтгэмж	629,728.7	513,543.3	116,185.4	81.5
Шагнал, урамшуулал, баяр ёслол	89,482.6	88,853.2	629.4	99.3
Төсөвт төвлөрүүлэх орлого	10,000,000.0	10,000,000.0	-	100.0
ОРЛОГО	33,600,581.0	39,846,814.4	6,246,233.4	118.6
Буулт хөөрөлтийн орлого	12,577,330.0	15,777,194.1	3,199,864.1	125.4
Буудлын хураамж	12,283,251.0	14,014,305.2	1,731,054.2	114.1
Үйл ажиллагааны бусад орлого	8,740,000.0	10,055,315.1	1,315,315.1	115.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019	Аудитын нэр: “Чингис хаан” Олон улсын нисэх буудал	Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/100/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Их хэмжээгээр худалдан авч нөөцөлснөөс 15.7 сая төгрөгийн маягт хүчингүй болж үргүй зардал гаргасан	15.7	зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	2013 онд гүйцэтгэж байсан албан тушаалтан
2	Дансны авлагын 12,782.4 сая төгрөгийн үлдэгдлийн 84.3 хувь буюу 10,810.7 сая төгрөг нь дотоодын авиа компаниудаас авах авлага байна. Эдгээрээс АэроМонголиа ХХК 1,227.4 сая төгрөг, МИАТ ХК 4,915.7 сая төгрөг, Хүннү Эйр ХХК 2,883.1 сая төгрөг, нийт 9,026.2 сая төгрөгийн авлага 3-с дээш жил болсон байна	9,026.2	зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Г.Халиунбигэр
3	Орон нутгийн нисэх буудлууд болон ИНЕГ-ын харьяа байгууллагуудтай холбоотой 93.5 сая төгрөгийн авлага, 240.1 сая төгрөгийн өглөгийг ИНЕГ-ын авлага, өглөгийн систем хоорондын тооцоогоор хааж, бэлэн бус тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар тохирч, системийн авлагыг 140.6 сая төгрөгийн цэвэр дүнгээр нэгтгэж толилуулсан нь Сангийн сайдын баталсан холбогдох заавар журамд нийцэхгүй байна	140.6	зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Г.Халиунбигэр
4	Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр, НБУГ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар 31.3 сая төгрөгийн хөрөнгийг НБУГ-т хүлээлгэж өгсөн боловч данс бүртгэлээс хасаагүй, жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй байна	31.3	зөвлөмж	Хүлээлгэн өгсөн албан тушаалтнууд	Д.Эрдэнэ-Очир, Ц.Эрдэнэчимэг, Ц.Дөлгөөн
5	Удирдлага буруутай шийдвэр гаргаснаас үндэслэлгүй халагдсан ажилтанд 2.7 сая төгрөгийн нөхөн олговор олгосон	2.7	зөвлөмж	Захирал	Д.Мөнхбаатар
6	Худалдан авах ажиллагааны төсөвт өртгийг хоёр хувааж төлөвлөснөөс, 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 4 нэр төрлийн 382.7 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авсан байна.	207.8	Албан шаардлага	Захирал Төлөвлөлт хэлтсийн дарга, Аж ахуй хангамжийн хэлтсийн дарга	Д.Мөнхбаатар, Н.Замбуулин, Ч.Отгонжаргал
7	Жижиг мөнгөн кассын үйл ажиллагааны журмаар зөвшөөрөгдөөгүй, заагдсан үнийн дүнгээс давсан 9.9 сая төгрөгийн зардлыг бэлнээр зарцуулсан	9.9	зөвлөмж		

8	Кассаар хүлээн авсан орлогыг тухай бүр харилцах дансанд тушаагүйгээс зарим саруудын кассын үлдэгдэл өндөр байна. Тухайлбал: 2019 оны эхний үлдэгдэл 16.5 сая, 3 дугаар сар 34.2 сая, 9 дүгээр сар 10.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй		зөвлөмж	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Г.Халиунбигэр
ДҮН		9,434.2			

Дотоодын авиакомпаниудаас авах авлагын дүн, насжилтаар

/төгрөг/

" ХҮННУ ЭЙР" ХХК-ний ТООЦОО

Утга	2012 он	2013 он	2014 он	2015 он	2017 он	2018 он	Нийт
Буул хөөрөлт	354,025,928.90	546,505,719.50	440,627,521.75	114,857,610.83	412,877,822.00	390,064,569.83	2,258,959,172.81
Бүртгэх цэг		92,264,000.00	80,752,000.00		91,802,000.00		264,818,000.00
Буудлын хураамж		421,781,000.00	583,174,000.00				1,004,955,000.00
Хүзүүвч		99,283,337.00	82,247,668.00				181,531,005.00
Байр түрээс		23,407,128.00			899,970.00		24,307,098.00
Самбар түрээс		9,405,000.00					9,405,000.00
Ачаа шуудан		10,065,185.94	11,784,123.60		4,322,825.93		26,172,135.47
Зогсоол					767,548.45		767,548.45
Электрон систем		15,934,289.86					15,934,289.86
Зорчигчий сумалгаа		1,000,000.00					1,000,000.00
Бусад		1,180,000.00			829,752.64		2,009,752.64
Нийт дүн	354,025,928.90	1,220,825,660.30	1,198,585,313.35	114,857,610.83	511,499,919.02	390,064,569.83	3,789,859,002.23

" АЭРОМОНГОЛИА " ХХК-ний ТООЦОО

Утга	2012 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Нийт
Буул, хөөрөлт	57,548,214.52	245,404,499.25	206,228,085.75	38,859,870.85	228,251,174.00	776,291,844.37
Бүртгэх цэг	13,454,000.00	83,986,000.00	66,782,541.50		697,459.97	164,920,001.47
Буудлын хураамж	62,739,000.00	423,660,000.00				486,399,000.00
Бүртгэлийн систем	5,872,000.00	-				5,872,000.00
Ачаа шуудангийн хураамж	799,887.80	6,206,903.68				7,006,791.48
Бусад		430,000.00				430,000.00
Зогсоол	-	124,466.18				124,466.18
Түрээс	1,688,862.00	9,803,106.00	-			11,491,968.00
Нийт	142,101,964.32	769,614,975.11	273,010,627.25	38,859,870.85	228,948,633.97	1,452,536,071.50

" МИАТ " ТӨХК-ний ТООЦОО

Утга	2012 он	2014 он	2015 он	2016 он	Нийт
Буул хөөрөлт	2,403,968,100.00	2,136,857,643.30	239,916,905.55	571,925,569.09	5,352,668,217.94
Бүртгэх цэг	183,029,748.00				183,029,748.00
Нийт	2,586,997,848.00	2,136,857,643.30	239,916,905.55	571,925,569.09	5,535,697,965.94



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 01/120

Улаанбаатар хот

САГ-2020/100/СТА-ТӨҮГ

Зөрчлийг арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд Буянт-ухаа дахь "Чингис хаан Олон улсын нисэх буудал" ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 2 нэр төрлийн 207.8 сая төгрөгийн бараа, бүтээгдэхүүнийг харьцуулалтын аргаар худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан Олон улсын нисэх буудлын захирал Д.Мөнхбаатар, Аж ахуй хангамжийн хэлтсийн дарга Ц.Жавхлантөгс нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САГ-ЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР *[Signature]* Л.МӨНХЦАЦРАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН
НИСЭХ БУУДЛЫН ЗАХИРАЛ
[Signature] Д.МӨНХБААТАР
АЖ АХУЙ ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА 5055954-1116116721
[Signature] Ц.ЖАВХЛАНТӨГС

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тоогуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Birkhe_Kherep\Alban_Shaardлага\2020\0317SAG5.Docx

001080429